

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ 05 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2020 оны 06 дугаар сарын 02

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2020 оны 05 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит 7 дугаар 5-р сарын 14-ний өдөр хуралдаж 5 асуудал хэлэлцэн 3 тогтоол баталж, тэмдэглэлээр 2 үүрэг өгөв. Үүнд:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийг 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэхийг даалгав.

2.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлтэй иргэдийн өргөдлийг хүлээн авч Батсүмбэр суманд 10, Баянжаргалан 4, Зуунмод суманд 5, Жаргалант 3, Мөнгөнморьт 3, Эрдэнэсант суманд 5, нийт 30 иргэн байхаар батлав.

3. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны I дүгээр улирлын тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийг хэлэлцээд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт үнэлгээ хийхдээ тухайн Тэмдэглэл гарсан өдрөөс хойш хийсэн ажил, түүний үр дүн, өгсөн үүрэг, тавьсан зорилт хэрхэн хэрэгжсэн байдалд үнэлэлт өгч, цаашид анхаарах асуудлыг тодорхойлсон дүгнэлтийг танилцуулж байхыг аймгийн Засаг даргад даалган хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

4. “Дэлгэрэх арвайн тал” ХХК-ийн хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэх тухай асуудлыг хэлэлцээд “Санал өгөх тухай” тогтоолыг батлав.

5. Бэлчээрийн газраас тариалангийн газарт шилжүүлэх санал уламжлах тухай асуудлыг хэлэлцээд боловсруулалтыг сайжруулан 7 дугаар сард хуралдах аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 17 дугаар хуралдаанд өргөн мэдүүлэхийг үүрэг болголоо.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 8 дугаар хуралдаан 5-р сарын 28-ны өдөр хуралдаж 6 асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын ээлжит 17 дугаар хуралдааны товыг 2020 оны 7 дугаар сарын 02-ны өдөр хуралдуулахаар тогтов.

2. Бурхан багшийн их дүйцэн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх талаар чиглэл өглөө.

3. Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих аймгийн хөтөлбөр /2019-2020/-ийн хэрэгжилтийг дүгнэсэн.

4. Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2017-2020/-ийн хэрэгжилтийг дүгнэлээ.

5. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэлэлцэв.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд: Аймгийн Засаг даргын зөвлөл 5 дугаар сарын 08-ны өдөр хуралдаж 8 асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Хөдөөгийн багийн иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн 36.1 сая төгрөгөөр Аргалант, Архуст, Баяндэлгэр, Заамар, Мөнгөнморьт, Цээл суманд багийн “Явуулын төв”-ийн иж бүрдэл олголоо.

ЗГ-ын 11-11 төвөөс 2020 оны 05-р сарын байдлаар өссөн дүнгээр 13 өргөдөл бүртгэн, хяналтанд авч ажилласнаас 9 өргөдлийг холбогдох мэргэжлийн байгууллагад шилжүүлэн хууль журмын дагуу шийдвэрлүүлэв. Хугацаа болоогүй 4 өргөдөл байна.

Аймгийн нэгдсэн шуурхай 2 удаа зохион байгуулагдсан бөгөөд хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлт 88.3%-тай хэрэгжсэн.

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Сарангэрэлийн баталсан удирдамжийн дагуу Зуунмод сумын 6 багт бодлогын хэлтсийн дарга нараар ахлуулсан 6 ажлын хэсэг 2020 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр баг тус бүрт ажиллаж 35 иргэнээс 48 санал хүсэлт хүсэлтийг хүлээн авч, хариу өглөө.

Төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн систем хөтлөх сургалтад хамрагдаж, систем нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

2020 оны 05 дугаар сарын 29-ний байдлаар 67 иргэний материалыг /Үүнээс ТАХ 19/ аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэлээ.

2020 оны 5 дугаар сарын байдлаар аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр-3, Засаг даргын “Хүндэт жуух бичиг”-ээр 7 иргэнийг шагнаад байна.

Төрийн албаны стандартын хүрээнд: Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг Салбар зөвлөлөөс туслах түшмэлийн 5 төрлийн 60 сул орон тоон нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулж ажиллав.

Салбар зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон www.tov.gov.mn цахим хуудасны “ТАЗСЗ” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2020.05.29-ний байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	28
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	5
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	9
5	Төрийн албаны ерөнхий шалгалтын зар	9
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	1
НИЙТ ДҮН		52

2020 оны 05 дугаар сарын 29-ний байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн хувь
1	Албан бичиг	40	11	10	1	-
2	Өргөдөл, гомдол	6	4	4	2	-

Гадаад харилцаа: Япон улсын Тоттори мужид Хөдөө аж ахуйн дадлагажигчаар ажиллах төрийн албан хаагчийг сонгон, холбогдох материалуудыг бүрдүүлж хүргүүлэв. БНСУ-ын Кёнги аймгийн Пёнтак хотын захиргааны санхүүжилтээр хийгдэх аймгийн Нийтийн номын сангийн их засварын ажлын тендерийн төсвийн товчоог орчуулж хүргүүллээ.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: 2020 оны 5 дугаар сард Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт 23 байгууллага 300-аад төрлийн үйлчилгээг **5200** иргэнд, өдөрт дунджаар 250-300 иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд

зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний мэдээллийг “Өлзий”, TBS, Төв, Live TV, Сүлд телевизүүд, аймгийн албан ёсны веб сайт, пейж хуудас, мэдээллийн болон урсдаг самбар зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа бөгөөд 5 дугаар сард аймгийн веб сайтад **28**, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **57** мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ. Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **4-н** дугаарт **22** бүрэн хэмжээний нэвтрүүлэг бэлтгэн өгч, олон нийтэд хүргэсэн. Мөн бусад 7 төрлийн телевизүүдийн мэдээний цагаар **20** мэдээ мэдээлэл гарсан нь давтагдсан тоогоор **270** удаа цацагдсан байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн өдөр тутмын үйл ажиллагаатай танилцаж туршлага судлахаар Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын дарга, холбогдох хэлтсийн албан хаагчид ирж танилцсан.

Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **11** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ:

Төлөвлөгөөт хяналт, шалгалт: Тус газар нь тайлант хугацаанд 15 хяналтын чиглэлээр 10 сумын иргэн, аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт шалгалт 78+4, зөвлөн туслах үйлчилгээ 21+3 хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 175+16 заалттай 29+4 албан шаардлага, 48 заалттай 7 зөвлөмж хүргүүлсэн. Урьдчилан сэргийлэх хяналт 2 хийж 13 объект, тандалт судалгаа 2 хийж 11 объект хамруулсан байна.

Төлөвлөгөөт бус шалгалт: Архуст, Баяндэлгэр, Баянжаргалан, Эрдэнэ сумдад 19/52, 19/30 тоот удирдамжийн дагуу 05 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд ажиллаж Архуст сумын соёлын төвд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар 11 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг чиглэл өгч, дээрх сумдын цэцэрлэгийн гадна орчны аюулгүй байдалд тандалт судалгаа хийлээ.

Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын чиглэлээр: Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтан үлийн цагаан оготнотой Баянжаргалан сумын бэлчээрийн 2000 га талбайд микробиологийн аргаар, 4000 га талбайд энгийн механик аргаар тэмцэх ажлыг зохион байгуулсан байна. Эрдэнэ суманд 3000 га талбайд микробиологийн аргаар, Баяндэлгэр суманд 2000 га бэлчээрийн талбай, Архуст сумын 56 га талбайд энгийн механик аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажилд хяналт хийсэн. “Хөрсөө хойч үедээ хэвээр үлдээ” сарын аян зохион байгуулж холбогдох байгууллагуудтай хамтран цахим сургалт явуулж, зөвлөгөө, зөвлөмж, постер, инфографик хийж пейж хуудсаар сурталчилж байна.

Байгаль орчны хяналтын чиглэлээр: Улсын хэмжээнд “Зөв дадал-Ногоон ирээдүй” сарын аяныг зарласантай холбогдуулан Төв аймгийн 27 сумын Засаг даргад улсын байцаагчийн 5 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн. Цахим орчинд хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлан 7 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлгийг постер хэлбэрээр бэлтгэж /inspection.gov.mn/ вэб сайт, фейсбүүк пейж, хуудсаар олон нийтэд сурталчлан ажиллалаа.

Итгэмжлэгдсэн лаборатори нь: Тайлант хугацаанд хяналт шалгалт, ААН иргэний хүсэлтийн хүрээнд 192 сорьцыг шалгаж 656 үзүүлэлтээр үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олгосон. Үүнээс ундны ус болон үрийн төмсний 8 сорьц 9 үзүүлэлтээр химийн болон нян судлалын шинжилгээний дүнгээр стандартын шаардлага хангаагүй. Мөн лабораторийн итгэмжлэлийн хугацааг сунгуулах бэлтгэл ажлын хүрээнд бодлого, удирдлагын тогтолцооны журмуудыг батлуулж, 1 давхарын лабораторийн 11 цонхыг төмөр хаалттай болгож үйл ажиллагааны 8 самбарыг шинэчилсэн.

Онцгой байдлын газрын хүрээнд: Зуунмод сум болон хөдөө орон нутгийн хэмжээнд аюулт үзэгдэл ослын дуудлагагүй бөгөөд Зуунмод сумын хэмжээнд нийт 3 удаагийн гал түймрийн зөрчлийн дуудлага бүртгэгдэж, 1 удаагийн объектын гал түймрийн дуудлага бүртгэгдлээ. Техникийн холбогдолтой ослын дуудлага 1 бүртгэгдэж 2 буцалтгүй нэрвэгдэгчтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан газар хөдлөлтийн аюулыг ард иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулж ТВ хичээл болон онлайн сургалтад хамрагдсан хүний тоо тандалт судалгааг гаргахад 27 сумын хэмжээнд нийт 10800 хүнд хүрсэн байна. Телевизээр цацсан теле сургалтад нийт 20.000 өрх, ЮНИВИШН төхөөрөмжөөр дамжуулан нийт 12.000 өрх, ОД төхөөрөмжөөр дамжуулан нийт 7800 өрх үзсэн байна.

Коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор халдвар хамгааллын болон хяналт шалгалтын ажлыг хяналтын байцаагч нар 7 хоног бүр төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудаар зохион байгуулж байна.

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 05 сарын дугаарыг “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн сэдвээр бэлтгэн нийтэд хүргэлээ.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 44 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, 58 иргэн, байгууллагад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлж, Дотоод удирдлагын системээр шинэ хууль тогтоомжийн 14 мэдээлэл оруулж, төрийн албан хаагчдыг хууль, эрх зүйн мэдээ мэдээллээр хангасан.

Аймгийн Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 6 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож тайлбар дүгнэлт гаргаж, 4 шүүх хуралдаанд оролцож ажиллалаа.

Аймгийн вэб сайтанд “Эрх зүйн сурталчилгаа” булан нээж, 4 хуулийн тайлбар, асуулт хариултын материалыг байршуулсан. Хууль эрх зүй хэсэгт www.e-khutuch.mn, www.legalinfo.mn сайтууд болон хэм хэмжээний акт, аймгийн шийдвэр гэсэн цэсүүдийг нэмж, баяжилт хийж эхэллээ.

Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зарласан “Байгалиа хамгаалъя” нэгдсэн аянд аймгийн ГХУСАЗСЗ, аймгийн ЗДТГ нэгдэж, сумдын салбар зөвлөлд тусгайлсан аяны төлөвлөгөө батлан хүргүүлж, видео шторик бэлтгэн олон нийтэд сурталчлан ажиллав. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс санаачлан орон нутгийн Төв телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, 1 жилийн хугацаанд хууль хяналтын байгууллагууд цувралаар оролцох “Түвшин-амгалан” нэвтрүүлгийг бэлтгэж, олон нийтэд хүргэв.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, мэдээллийг аймгийн ИТХТ-ийн 05 дугаар сарын 28-ны өдөр хурлаар хэлэлцүүлжээ. Мөн АТГ-тай хамтран аймгийн ЗДТГ-ын Хуулийн зөвлөх, ХАА-н мэргэжилтэн, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн нарыг хамруулан “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төрөөс олгож буй санхүүжилтийн талаар” цахим сургалт зохион байгууллаа.

Төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр сумдын Засаг дарга нарт чиглэл өгч, 27 сумын Засаг даргын Тамгын газрыг “Нууц хамгаалах журам”-тай болгосон. 13 сумын Засаг даргын Тамгын газрын “Нууц хамгаалах ажилтан”-г томилох асуудлаар Төв аймаг дахь Тагнуулын хэлтэст холбогдох барим бичгийг хүргүүлэв.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 138 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг сумдад хүргүүлсний дагуу Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Зуунмод, Жаргалант сумын ИТХ болон ЗДТГ-тай хамтран шашны байгууллагад хяналт шалгалтыг зохион байгуулж, улс, аймгийн онцгой комиссын шийдвэрийг хэрэгжилтийг хангууллаа.

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн Ажлын Албанаас 2020 оны 05 дугаар сарын 11, 12-ны өдөр манай аймагт ажиллаж “Ажил эрчимжүүлэх” чиглэл өгсөн.

Нотариатын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан өмнө ашиглаж байсан 27 сумын нотариатын баталгааны нийт 158 тэмдгийг хураан авч устгах арга хэмжээг авав.

Архивын үйлчилгээ: Төрийн архивын эх баримтаас 267 иргэний хүсэлтээр 632 хуулбар хувь, 128 лавлагаа, 288 хөмрөгийн 1074 хадгаламжийн нэгж ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилж, 1.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.

6 хөмрөгийн 274 хадгаламжийн нэгжийн 8754 хуудас баримтын 42650 хүний нэр, 7372 заалтын тоо, тушаалын мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердаж, 4 хөмрөгийн 99 хадгаламжийн нэгжийн 7373 заалтын 8719 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэж, 6 хөмрөгийн 1072 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтэс: Эд хөрөнгийн бүртгэл: Цахим санд нийт 55733 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 10089, Газар өмчлөх эрхийн 45644 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 20161.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 1.1 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл: Тайлант хугацаанд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 43 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлж, 87 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Тэмдэгтийн хураамжийн орлого 2.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.

Цагдаагийн байгууллагын мэдээлэл: Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 350 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 хэргээр буюу 2.7 хувиар буурсан. Гэмт хэргийн илрүүлэлт 38,1 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,8 хувиар өссөн.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа: Гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-25, шүүхээр баривчлагдсан-66, албадан саатуулагдсан-9, ар гэрт нь хүлээлгэн өгсөн-10, нийт 110 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд эрүүлжүүлж, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Аймгийн онцгой комиссын шийдвэр, Засаг даргын А/249 дүгээр захирамжийн дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг дэвсгэрийн 3 цэгт тусгаарлах байрны хамгаалалтад 9 алба хаагч ажиллалаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 74 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасч, 8 иргэнийг сум дундын шүүхээр баривчлуулж, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 3792 жолоочийг 122.530.0 төгрөгөөр торголоо.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр: Криминалистикийн шинжилгээ-72, Магадлан шинжилгээ-72, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-299, гарын мөрийн санг баяжуулсан-172, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 358 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
5-р сар	321	209	25	505	188	317	37.2%
	4335531.9	1181138.0	892358.5	4624284.4	795171.9	3829112.5	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд

ХАА-н чиглэлээр: Газар тариалангийн хүрээнд: Аймгийн хэмжээнд 2020 онд 95.4 мян.га-д үр тариа, 7.8 мян.га-д төмс, 1.6 мян.га-д хүнсний ногоо, 1.6 мян.га-д тэжээлийн таримал, нийтдээ 116.4 мянган га талбайд тариалалт хийхээр төлөвлөсөн. 05-р сарын 25-ны байдлаар үр тариа 17.9 мян.га-д, төмс 2.9 мян.га-д, хүнсний ногоо 0.2 мян.га-д, тосны ургамал 1.1 мян.га-д, жимс, жимсгэнэ 6.8 га-д тус тус тариалаад байна.

НҮБ-ийн Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас цар тахлын улмаас үүсч болох хүнсний хомсдолоос урьдчилан сэргийлж хүнсний ногооны үйлпвэрлэлийг нэмэгдүүлэн 10 суманд 4.7 сая төгрөгийн 98 кг үр, “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 24 суманд, 7.7 сая төгрөгийн 236.5 кг үр нийт 9,4 сая төгрөгийн 334,5 кг үр нийлүүлэх ажлыг зохион байгууллаа.

Жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэн 3 сумын 35 иргэнд чацарганы суулгац 220, үхрийн нүдний суулгац 60 ширхэгийн тус тус нийлүүлж, тарих, арчлах технологи, зөвлөгөө мэдээллээр хангав.

Хөдөө аж ахуйг дэмжих сан, Агромаш ХХК-аас хаврын тариалалтын ажлыг эрчимжүүлэх техник тоног төхөөрөмж шинэчлэх ажлын хүрээнд 50-220 морины хүчин чадалтай трактор-13ш, сийрүүлэгч-2ш, хийн үрлэгч-1ш, хадлангийн иж бүрдэл-4ш, услалтын систем /15-100 га/-6ш, мотоблок-9ш нийлүүлэгдэж тариалалтад ашиглаж байна.

Мал аж ахуйн хүрээнд: Аймгийн хэмжээнд 12056 малчин өрхөд 4.9 сая толгой мал хаваржиж 2.3 сая толгой хээлтэгч мал төллөхөөс 1738553 толгой мал төллөж, 1745011 толгой төл гарсанаас 1707452 толгой төл бойжиж байна. Гарсан төлийн 37559 толгой төл мал хорогдсон нь нийт бойжиж буй төлийн 2.1 хувийг эзэлж байна. Оны эхний малын 0.71 хувь буюу 35488 том мал зүй бусаар хорогдсон.

Аймгийн хэмжээнд 94 суурьт 24243 толгой хээлтүүлэгч /хуц 12249, ухна 7356 толгой/ малыг ялган суурилах ажлыг зохион байгууллаа.

Бэлчээрийн хөнөөлт мэрэгчтэй тэмцэх ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр 14 суманд 100.0 мян/га тэмцлийн ажлыг энгийн меаник аргаар хийж, Микробиологийн аргаар тэмцэх 75 тн будааг 26 суманд хуваарилсан.

Аймгийн аюулгүйн нөөцөөс 27 суманд 320 тн өвс, 80 тн тэжээлийг хямд, хөнгөлөлттэй нөхцөлөөр хуваарилан, 20 тн тэжээл нөөцөд төвлөрүүлээ.

2020 онд 5 сумын 12900 толгой малд үзлэг ангилалт хийж, бүртгэлжүүлэхээс үзлэг ангилалт 3156 толгой хонь, 243 толгой адуу хамрууллаа.

Ноолуурын урамшуулалд хамрагдах малчдын “А” дансны бүртгэл, харилцах дансны судалгааг авч нэгтгэн ХХААХҮЯ-нд уламжилсан. 2019 онд тушаасан ноосны урамшуулал 3424 малчин 851.7 сая, арьс, ширний урамшуулал 2827 малчин 998.2 сая төгрөг авсан.

Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд: ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээлийн хүсэлтийг 15 сумын 44 аж ахуй нэгж ирүүлснийг VERITECH ERP программд бүртгэж баталгаажуулан, 56 аж ахуй нэгжид тодорхойлолт олголоо.

Аймгийн төвийн иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн хөөрөгдлийг бууруулах зорилгоор Зуунмод мах боловсруулах ТӨҮҮГазартай хамтран Зуунмод сумын 7-н хүнсний дэлгүүрээр нөөцийн махны худалдаа хэвийн явагдаж байна. Эрдэнэ хүнс, Экофүүдс, Зуунмод мах боловсруулах махны үйлдвэрүүдэд 3.5 тн махны нөөцийн үлдэгдэлтэй байна.

НҮБ-ын ХХААБайгууллагын SECIM-2 төсөл, Төв телевизтэй хамтран “Үхэр, хонины мах хэрэглээний зориулалтын дагуу шулж ангилах үзүүлэх” цахим сургалтыг шууд дамжуулан Эрдэнэ, Баяндэлгэр мах боловсруулах үйлдвэрийн 30 ажилтан хамрууллаа.

Мал эмнэлгийн үйлчилгээ: Биокомбинат УТҮГ-тай байгуулсан гэрээ дагуу вакцин нийлүүлэлт 86.7 хувьтай байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1803.6 мян/мал хамруулахаас вакцинжуулалт 38.04 хувьтай байна.

Нийт ариутгал, халдваргүйтгэлийг **637.0** мян/м² талбайд хийх ажлыг зохион байгууллаа. Үүнд:

- Малын сэг зэм 20285 устгаж - 11.8 мян/м² талбай
- Хашаа, хороо, өтөг бууц, худаг уст цэгийн талбай - 332.2 мян/м²
- Бэлчээрийн талбай - 24.2 мян/м
- Агуулах, зоорь, түүхий эд агуулах цэгийн талбай - 44,0 мян/м²,
- Устгалын цэг - 11,8 мян/м²
- Нийтийн эзэмшлийн зам талбай - 213,0 мян/м²

Манай аймагт гадны аймаг сумд, өөрийн аймаг сумдаас отроор ирсэн 706 өрхийн 442334 мал өвөлжснөөс 297 өрхийн 176112 мал буцаж 409 өрхийн 224068 мал буцаагүй байна. Аймгаас гадны аймаг сум руу болон өөрийн сумдад оторлож байгаа 232 өрхийн 166003 малаас 52 өрхийн 93060 толгой мал буцан ирж 180 өрхийн 72943 мал ирээгүй байна.

Мал эмнэлгийн нэгдсэн системээр 7045 цахим гэрчилгээ олгож, 1346 малын эрүүл мэндийн дуудлагын үйлчилгээ үзүүллээ. Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг 4 ээлжээр 24 цаг хэвийн ажиллаж, малын шилжилт хөдөлгөөн болон 1028 тээврийн хэрэгсэлд хяналт тавин ажиллалаа.

Дэд бүтцийн чиглэлээр: *Барилга хот байгуулалт, газрын харилцааны үйлчилгээний хүрээнд:* Сангийн яам, БХБЯ-ны хамтран улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй барилга байгууламжийн барилга захиалагчийн үйл ажиллагаа, түүний үр дүнд аудит хийж байна. Энэ ажлын хүрээнд Зуунмод хотын усан хангамжийн 2х2000м³/хон цэвэр усны нөөцийн сан, шугам сүлжээний угсралтын ажил, Эрдэнэ сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын угсралтын ажил, Баян сумын 75 ортой дотуур байрны барилгын угсралтын ажил, Алтанбулаг сумын спорт заалны барилгын ажлын явцтай танилцаж, үүрэг чиглэл, зөвлөмж өгч ажилласан.

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, нийгмийн болон инжинерийн дэд бүтцийн өгөгдөл мэдээллийг бүрдүүлэх ажлын хүрээнд Зуунмод сумын 453 барилга байгууламжийн мэдээллийг оруулсан байна. 6 барилгын зураг төсөл, барилга байгууламжид барилга эхлүүлэх зөвшөөрөл олгогдож, 6-н барилга байгууламж ашиглалтад оруулав.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/605 дугаар захирамжаар байгуулагдсан “Газар зүйн нэрийн салбар зөвлөл”-ийн анхдугаар хуралдаан 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдлаа.

Хаягийн мэдээллийн сангийн өгөгдлийг газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөлтэй болон газар дээрх хаягжуулалттай харьцуулан шалган **40 барилга, 18944 хашааг** кадастрын мэдээллийн сангаас төлөвлөлтийн давхрагад оруулж, 10284 хашаа, 1237 байшингийн орц, гарцыг цэгэн мэдээллээр тэмдэглэж оруулсан.

Газрын төлбөрийн орлого 1208333.3 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1130120.1 мянган төгрөгийг төвлөрүүлж 93.5%-ийн гүйцэтгэлтэй байна. Аймгийн хэмжээнд 7 сумын 47 нэгж талбарт дуудлага худалдааг зохион байгуулж дууссан.

Зам харилцааны хүрээнд: Зуунмод сумын Ланс багийн чиглэлийн 0.64 км авто замын ажлын гүйцэтгэгчээр “Төв АЗЗА” ТӨХК-н шалгарч зам барилгын ажил эхлэлээ.

Байгаль орчны чиглэлээр: “Мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулж, аймгийн хэмжээнд 30.0 мянга орчим мод тарьлаа.

Баянцагаан суманд хэрэгжих “Олон наст ургамал тариалах ажил”-ын тендерт шалгарсан ААН-тэй гэрээ байгуулж, тариалалтын ажлыг эхлүүллээ.

Туул, Хэрлэн голуудын дагуу загас үржүүлэх, жимсны модны бут сөөг тарих үржүүлгийн газар байгуулах төслийн ТЭЗҮ-г мэргэжлийн байгууллагаар гүйцэтгэх шууд гэрээ байгуулах анхны хэлэлцээр хийсэн.

Баянчандмань, Борнуур, Жаргалант сумдын 11 амралт аялал жуулчлалын газар, 1 сувилал, 5 хувиараа фермер эрхлэгч, 1 хоёрдогч түүхий эд авах цэгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулсан.

Эрдэнэ, Баяндэлгэр суманд ашигт малтмалын болон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 7 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулж, 1 аж ахуйн нэгжийн техникийг лацдаж, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийллээ.

Орон нутгийн өмчийн чиглэлээр: 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 103 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 82 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж хэрэгжүүлэхээс 5 дугаар сарын гүйцэтгэлээр нийт 73 төсөл, арга хэмжээнд үнэлгээний хороог байгуулж, цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулснаар хэрэгжилт 93%-тай байна.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээ: Баян, Баяндэлгэр, Батсүмбэр, Мөнгөнморьт, Зуунмод, Баянцагаан, Алтанбулаг, Эрдэнэ, Баянчандмань суманд худалдаа, үйлчилгээний 146 бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирлын үнэлгээ, 452 ш хэмжих хэрэгсэл, эзэлхүүн зарцуулалтын баталгаажуулалт хийлээ.

Орон тооны бус баталгаажуулалтын зөвлөлийн 2020 оны 05-р хуралдааныг хуралдуулсан. Тус хурлаар Зуунмод, Баян, Батсүмбэр, Баянцагаан, Алтанбулаг сумдын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийсэн тайланг хэлэлцүүлж, хурлын шийдвэрийг үндэслэн нийт 45 үйлчилгээ, 2 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгосон.

Сэргэлэн, Зуунмод сумын худалдаа үйлчилгээ, мөнгөн тооцоонд ашиглаж байгаа нийт 22 ш массын хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажуулав.

Эзэлхүүн зарцуулалтын лаборатори нь: “НИК-Петровис” ХХК-ний Дархан НХСалбар, “Тэс петролиум” ХХК, “Шунхлай трейд” ХХК, “Хөрс авто сервис” ХХК-ний аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ШТС-ын хэмжих

хэрэгслүүдэд улсын I-р ээлжит баталгаажуулалтыг хийж, 80 хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулсан.

Жаргалант, Борнуур, Цээл, Заамар сумдын айл өрх, аж ахуй нэгжийн ашиглаж байгаа 1,3 фазын нийт 350ш цахилгаан тоолуурыг шалгаж баталгаажуулав.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2020 онд ЭЕШ өгөх 20 сургуулийн 12-р ангийн сурагчдыг ариутгал халдваргүйтэл, хорио цээрийн дэглэмийг баримтлан 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн танхимын давтлага өгч байна.

“Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд “Аймгийн хэлний бодлогын Салбар зөвлөл”-өөс “Төв аймгийн сайхан бичигтэн-2020” цахим уралдаан, “Монгол бичигтэн-Байгууллага, хамт олон”, “Үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэгч багш” болзолт уралдаануудыг зарлан “Төв аймгийн сайхан бичигтэн-2020” цахим уралдааны II шатны дүн гарч шилдгүүдээ тодрууллаа.

Аймгийн нутаг дэвсгэр дэх Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудын солилболцлын цэг, байршлыг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, шатахууны зардалд шаардагдах нийт 1126986 төгрөгийг шийдвэрлүүллээ.

Нийтийн биеийн тамир, их спорт, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих аяны удирдамжийг боловсруулан батлуулж 2020 оны 05 дугаар сарын 18-наас эхлэн нэг жилийн хугацаатай зарлалаа.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээнд Мерит төсөлтэй хамтран аймгийн удирдлагууд болон салбар хорооны гишүүдийг чадавхжуулах танхимын болон цахим сургалт зохион байгуулж, ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ цахим сургалтад 78 хүн, “Хүчирхэг илтгэл”танхимын сургалтад 2 гишүүнийг хамруулж чадавхжуулсан.

Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ: Хөл хорио тогтоосонтой холбогдуулан теле хичээлийг аймгийн хэмжээнд зохион байгуулж, ЭЕШ-д бэлтгэх чиглэлээр Төв аймаг-ЭЕШ пэйж хуудас нээн ажиллуулж, БСУГ-ын вэб сайтад судлагдахуун бүрээр цахим хичээл байршуулан бэлтгэл хангаж байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан цахим сургалтад хамрагдаж Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, статитик мэдээ мэдээлэл боловсруулах, танилцуулга бэлтгэх зэрэг 4 чиглэлээр онлайн шалгалт өгч 85,7%-94,5%-тай үнэлэгдлээ.

Сумдын Соёлын төвийн эрхлэгч, хөгжим, бүжгийн багш, номын санч нарт “Соёлын үйлчилгээг цахимаар хүргэх” сэдэвт сургалтыг нийт 95 ажилтан, албан хаагчид явуулсан.

Албан бус насан туршийн боловсролын Үндэсний төвөөс өгсөн “Хүнсний нарийн ногоог гэрийн нөхцөлд хэрхэн тарих арга аргачлал” сэдэвтэй цахим хичээлийг Борнуур. Эрдэнэ суманд зохион байгууллаа.

Монгол туургатан театрын үйлчилгээ: Тайлант хугацаанд 4 төрлийн цахим арга хэмжээг зохион байгуулж нийт 14300 иргэнд хүрч үйлчилсэн тандалттай байна.

Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театр, Архангай аймгийн Хөгжимт драммын театрын уран бүтээлчидтэй хамтран “Цахим” тоглолтыг зохион байгууллаа.

Музейн үйлчилгээ: Аймгийн Музей, Нийтийн номын сан хамтран Баянхангай, Цээл, Угтаалцайдам сумдын соёлын төвийн үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.

“Олон улсын Музейн өдөр”-ийг тохиолдуулан “Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо” ТББ-тай хамтран сонсголын бэрхшээлтэй иргэдэд музейн үйл ажиллагаа, онцлох үзмэрийн талаарх мэдээллийг багтаасан “Төв нутгийн соёлын өвөөс” нэвтрүүлгийг “TBS” телевизээр нэвтрүүллээ.

Сумдын соёлын төвийн эрхлэгч нарт “Тахилга шүтлэгт газар нутаг, тахин шүтэх зан үйлийн өнөөгийн байдал, сэргээн тэтгэх арга зам”, “Чулуун соёлын өв”, “Соёлын биет бус өвийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөрийн талаарх мэдээлэл, Музейн стандартыг “Орон нутаг судлах танхимд” хэрэгжүүлэх нь сэдвүүдээр цахим сургалтыг хийсэн.

Нийтийн номын сангийн үйлчилгээ: “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдуулан “Бидний бахархал бичиг үсэг” номын үзэсгэлэнг Facebook page хуудас болон веб сайтад байршууллаа. “Дэлхийн номын өдөр”-ийг тохиолдуулан иргэд, хүүхэд залуучуудад Алтанбулаг сумын уугуул Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, яруу найрагч Ш.Цэрэндоо гуайн бэлтгэсэн нэвтрүүлгийг вэб сайт, Facebook page цахим хуудсанд байршуулж танилцуулсан. Мөн “Анхдугаар таван жил” 1964 оны сонинг скайнердаж PDF файл болгож цахим санд байршууллаа.

Номын сангийн үндсэн фондоос “Насанд хүрэгчдийн уншлагын танхим”-д **12058** болон “Хүүхдийн уншлагын танхим”-д **7811** хуваарилан нийт **19869** номуудыг электрон каталогит тулгалт хийсэн.

Биеийн тамир, спортын үйлчилгээ: Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу сумдын биеийн тамирын хамтлаг, спорт заалны үйл ажиллагаатай танилцах, алхалт гүйлтээр хичээллэх иргэдийг идэвхжүүлэх, ажлын байрны дасгалыг тогтмолжуулах, 640 хүүхдийн төрөлжсөн сургалттай сургуульд суралцах тамирчдын судалгааг гаргах, Олимп хөгжлийн сангийн цом аялуулах бэлтгэл ажлыг хангуулахаар 27 суманд ажиллалаа.

Нарны алхалтыг 04-р сарын 27-ноос эхлүүлэн Зуунмод суманд алхалт, гүйлт, дугуй унадаг иргэдийн судалгааг чиглэл бүрт гаргахад тогтмол идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэдэг 266 хүн бүртгэснээс эр 87, эмэгтэй 179 хүн байна. Мөн тогтмол дугуйгаар хичээллэж буй хүн 32 байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ: Олон Улсын Гэр бүлийн өдрийг угтан “БҮХ ХАЙРАА-ГЭР БҮЛДЭЭ” сарын аянг зохион байгуулж, Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн Төв аймаг дахь салбар, Төв телевиз, TBS телевизтэй хамтран “Хослох урлаг” нэвтрүүлгийн 2 дугаар, “Та хүүхдээ хэр сайн мэдэх вэ” контентийн 3 дугаар “Тэр намайг хэр сайн мэдэх вэ” контентийн 1 дугаар бэлтгэн, нийт телевизийн 6 нэвтрүүлэг, контент байгууллагын фэйсбүүк аккаунт, пэйж хуудас болон Төв телевизийн пэйж хуудсаар дамжуулан түгээж 10952 хандалт авсан байна. Мөн аяны хүрээнд ахуйн хүрээний архидалтыг багасгах, гэр бүлийн харилцаа үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор “Аз жаргалтай гэр бүл-Архигүй” цахим челленж, “Жаргалтай үрсдээ” эцэг эхчүүдийн захидлын уралдаан зохион байгуулж 86 гэр бүл хамруулан 102 фото зураг нийтлэн 897 хандалт авч, 71 захидал хүлээж авсан.

Монгол Улсад “Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн” үүсч хөгжсөний 95 жилийн ойг тохиолдуулан “Андууд” уран бүтээлийн нэгдэл, цахилгаан хөгжмийн “Оч” хамтлаг, Монгол туургатан театр, “Төв” телевизтэй хамтран “Залуучууд коронавирусийн эсрэг нэгдэж байна” уриан дор “Андууд 2020” цахим тоглолт, Төв аймгийн Хүүхдийн байгууллагын түүхэн хөгжлийг харуулсан гэрэл зургийн цахим үзэсгэлэнг 5 цуврал болгон олон нийтийн сүлжээнд түгээж, давхардсан тоогоор 9682 удаагийн хандалт авсан байна.

Гал түймрийн улмаас орон гэргүй болсон Эрдэнэ сумын иргэн О-ийн 2 хүүхдэд 516.750 төгрөгийн үнэ бүхий гутал хувцас, хоол хүнсний дэмжлэг

туслалцааг үзүүлж, Хүүхэд хамгааллын түргэвчилсэн үнэлгээг дахин хийж 12 сумын 102 өрхийн 355 хүүхдэд хоол хүнс, ариутгалын тусламжийг хүргэв. Гэмт хэргийн гэрч хохирогч болсон 2 хүүхэд, гэмт хэрэгт холбогдсон 1 хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн гэрч 3 хүүхдээс тус тус байцаалт мэдүүлэг авахад, 1 хүүхэд шүүх хуралд оролцоход хууль ёсны төлөөлөгчөөр оролцсон.

“Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр”-т зориулсан постер, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Гэр бүлийн боловсрол”, “Жендэрийн хэвшмэл хандлагаа өөрчилье” цахим мэдлэгийг цувралаар байгууллагын фэйсбүүк аккаунт, пэйж хуудсаар дамжуулан түгээж, давхардсан тоогоор 164 хандалт авсан байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц боловсрол олгох зорилгоор “Амьдрах ухааны 12 модуль” цахим хичээлийн эхний 2 дугаарыг “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Харилцаа ба үерхэл нөхөрлөл” сэдвүүдээр бэлтгэн түгээж, давхардсан тоогоор 1 619 хандалт авч, 86 мянган гишүүнтэй 4 группт шэйрлэгдсэн байна.

2020.05.01-2020.06.01-ний өдрүүдэд “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аян цахим орчинд зохион байгуулж 5 төрлийн видео шторк бэлтгэн түгээсэн.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ: 2020 оны 5-р сарын байдлаар 1849 иргэнд 1817.6 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1149 иргэнд 488.1 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 918 иргэнд 264.1 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 501 ахмад настанд 99.8 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 5151 ахмад настанд 417.9 сая төгрөгийн насны хишиг, 237 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 40.7 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 4130 иргэнд 305.7 сая төгрөг, жирэмсэн 831 эхэд 127.5 сая төгрөгийн тэтгэмж, алдар цолтой 59 ахмад настанд 46.5 сая төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 5513 эхэд 1075.4 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 284 эх /эцэг/-т 117.0 сая төгрөг, 2 ихэр хүүхэд төрүүлсэн 12 эхэд 24.0 сая төгрөг, алдарт эхийн 1, 2-р одонтой 8381 эхэд 941.2 сая төгрөгийг тус тус олгосон.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 29 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 33 ажил олгогч байгууллага, иргэн, 50 сул чөлөөтэй ажлын байр, 34-н ажилд зуучлагдсан иргэн, 146 шинэ /байнгын болон түр/ ажлын байрны мэдээллийн санд оруулав.

2020.05.12-16-ны хооронд Заамар суманд үйл ажиллагаа явуулдаг 9 ААНБ-д ажиллаж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа авч, 5 ААНБ-ын 65 шинээр бий болсон ажлын байр болон 2020 онд зуучлагдсан иргэдийн мэдээлэл цуглуулж, шаардлагатай байгаа 9 ажлын байрны захиалгыг бүртгэж, сургалт мэдээлэл өгсөн.

Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй Борнуур, Зуунмод, Баянчандмань, Эрдэнэ сумын 5 бүлгийн 25 иргэн, Бүлгээр хүнсний ногоо тариалах хүсэлтэй Борнуур, Сүмбэр, Жаргалант, Баянчандмань, Батсүмбэр, Зуунмод сумын 10 бүлгийн 51 иргэн, нийт 76 иргэнийг аж ахуй эрхлэлтийн бүлгийн сургалтад хамруулж байна.

ХХҮГ-ын Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн хуралдаанаас 12 сумын 21 иргэний төслийг хэлэлцэж 94,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, 37 ажлын байрыг бүртгэлээ. Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт олгох гэрээг 7 иргэнтэй байгуулсан. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 4 сумын 6 иргэнд 14,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ажлын байр хадгалах боломжийг олгосон.

Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлэхээр зөвлөх үйлчилгээ үзүүлэгч компани WORLD STANDART CONSULTING LLC-тэй гэрээ байгуулан, чанарын удирдлагын багийг газрын даргын тушаалаар томилж, ажлыг төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал 3 удаа хуралдаж, нийт 169 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 20 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 140 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 9 иргэнийг цуцалсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2/520 дугаар албан бичгийн хүрээнд 2018.01.01-нээс 2020.02.01-ний өдрийг хүртэлх хугацаанд шинээр тогтоолгосон 414 өндөр насны тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийг архивын эх хувьтай тулган шалгалаа. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын 1/538 дугаар албан бичгийн хүрээнд хийгдэх дотоод хяналт шалгалтыг сайжруулах ажлын төлөвлөгөөний дагуу 68 тэтгэвэр авагчийн мэдээллийг холбогдох баримт, мэдээллийн бааз дахь мэдээлэлтэй тулган шалгав.

Тэжээгчээ алдсаны тэжээгчийн регистрийн дугаар давхардсан 9 тэтгэвэр авагчийн мэдээлэл, хувийн хэргийг шалгаж давхардсан 3 тэтгэвэр авагчид 12,8 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоолоо.

2020 онд урьд оны шүүхийн шийдвэртэй ажил олгогчийн авлагаас 3 ажил олгогчийн 2,0 сая төгрөгийн авлагыг барагдуулж, шинээр 2 ажил олгогчоос 19,4 сая төгрөгийг нэхэмжлэн шүүхэд шилжүүлж 13,8 сая төгрөгийг төлүүлэн барагдуулав.

2020 оны 5 дугаар сарын 18-ны байдлаар 417 ААН-ийн 2330 даатгуулагчийг Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн ослын даатгалын зэрэг 4 сангийн 319,8 төгрөгийн шимтгэлээс бүрэн чөлөөлсөн байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд Татварын ерөнхий газраас ирүүлсэн үйл ажиллагаа нь доголдсон, орлого нь буурсан ААН-ийн жагсаалтад хамрагдсан 61 ААНэгжийн 273 даатгуулагчийн хөнгөлөлтөд хамруулахаар шийдвэрлэсэн.

Аймгийн хэмжээнд 14402 тэтгэвэр авагчдад 5.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон. Мөн 83 албан журмын даатгуулагч жирэмсэн амаржсаны тэтгэмж 129.6 сая, 66 даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 13.2 сая, 24 сайн дурын даатгуулагч жирэмсэн амаржсаны тэтгэмж 14.1 сая, 29 даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 4.9 сая, ҮОМШӨ-хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 1 даатгуулагчийн 591.1 мян.төгрөг, 17 даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж 49.6 сая, нийт 212 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Засгийн газрын 2019 оны 484 дүгээр тогтоолоор баталсан “Зарим иргэний тэтгэврийн нэмэгдүүлэхэд баримтлах журмын дагуу 1534 тэтгэвэр авагчдад 76700000 төгрөгийн нэмэгдлийг олгоод байна.

Эрүүл мэндийн үйлчилгээ: Аймгийн хэмжээнд 2020 оны 04 сарын байдлаар 349 эх төрж өнгөрсөн мөн үеийнхээс 2 тохиолдлоор өссөн ба 350 нярай бүртгэгдсэн. Нийт 102421 үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 34461, амбулаторийн үзлэг 47747, идэвхитэй хяналтын 9233 үзлэг хийж гүйцэтгэсэн. Түргэн тусламжийн дуудлагаар 6744 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 1750 буюу 25.95%, осол гэмтлийн дуудлага 164 буюу 2.43%-ийг эзэлж байна. Стационарт 4999 хүн эмчлэгдэн нийт 36466 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7,3 байна.

Халдварт өвчний сэжигтэй 16 тохиолдол бүртгэгдсэн. Үүнд: хачигт халдвар 2, салхин цэцэг 1, Ёлом 1, гэдэсний халдвар 1, хоолны хордлого 10, цочмог суулгалт 1 тус бүр бүртгэгдсэн байна. Тархвар зүйн судалгааг хийж голомтын ариутгал, халдваргүйтгэл хийлээ. Хачигт халдварын 2 сорьцийн шинжилгээг ЗӨСҮТ-д хүргүүлсэн.

Аймгийн Эрүүл мэндийн газрын төлөвлөгөөт хяналт-шинжилгээ, үнэлгээг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/179 тоот тушаалаар батлагдсан Сум, тосгоны эрүүл мэндийн төвийг магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу 26 сумын Эрүүл мэндийн төвд зохион байгууллаа.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 2015-2020 онд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний гэрээ, гэрээний хэрэгжилтэд хяналт хийлээ. 2015-2020 онд гэрээний хүрээнд 74 эмч, эмнэлгийн мэргэжилтэн үндсэн болон төрөлжсөн мэргэшлээр суралцаж, гэрээний дагуу тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын анхдугаар хурлаар 4 эрүүл мэндийн байгууллагын хүчинтэй хугацааг сунгаж, 2 байгууллагад шаардлага биелүүлэх албан тоот хүргүүлээ. Шинээр ирсэн 5 төсөл тэргүүлэх чиглэлд нийцээгүй учир дэмжигдээгүй, 2 эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг хяналтын чиг үүрэг бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн 3 сараар түр түдгэлзүүлсэн, 4 эрүүл мэндийн байгууллагад шинээр тусгай зөвшөөрөл олгосон.

Олон улсын сувилагч, эх баригчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Танд баярлалаа” хүндэтгэлийн онлайн тоглолт зохион байгууллаа. Онол практикийн бага хурлын шилдэг 3 байр, уран илтгэгч шалгаруулж, шагнаан урамшуулсан.

ЭМЯ-ны 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвд Пургон автомашин, АНЭ-т Засаг даргын хөрөнгө оруулалтаар 35.0 сая төгрөгийн яаралтай тусламжийн иж бүрэн тоноглогдсон автомашин нийлүүлэв.

Урианы жилийн ажлын хүрээнд “Урьдчилан сэргийлэх үзлэгийг иргэн бүрт аян”-ны 1-р шатны үйл ажиллагааг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 49.8 сая төгрөг, Аймгийн онцгой комиссоос 27 суманд 7.3 сая төгрөгийн бензин, нийт 57.1 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэсэн.

Батсүмбэр сумын Ахмад настны үндэсний төв, Баянбайгаль, Баянхангай амралтын газруудад ОХУ-аас ирсэн 88 хүн тусгаарлах байранд хяналтад байна. Гэрийн тусгаарлалтад 62 иргэнийг 18 сумын Эрүүл мэндийн төвийн хяналтад авсан, одоогоор 8 хүн хугацаа дуусаагүй ажиглалтад байна.

Аймгийн хэмжээнд 11917 ширхэг өндөр тунт А аминдэмийг 27 сумын Эрүүл мэндийн төвд хувиарласан байна.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлогын талаар: Орлогын төлөвлөгөө 4 дүгээр сарын байдлаар орон нутаг 1469,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 1291,1 сая төгрөг төвлөрүүлж 87,9 хувьтай, 12,1 хувиар буюу 178,1 сая төгрөгөөр тасалсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 5986,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 6541,4 сая төгрөг төвлөрүүлж 109,3 хувьтай, 555,2 сая төгрөгөөр буюу 9,3 хувиар тасарсан байна. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 640,7 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 107,3 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцогт, Борнуур, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр, Цээл зэрэг 14 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Баянцагаан, Баянчандмань, Бүрэн, Дэлгэрхаан, Жаргалант, Сэргэлэн, Угтаал, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод зэрэг 11 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баян, Баянжаргалан сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар: Сумдад эхний 04 сарын байдлаар нийт 28495,5 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл:

Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 13232,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулиудад 9088,2 сая төгрөг
- Хүүхдийн цэцэрлэгт 4144,7 сая төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 3026,6 сая төгрөгийг олгосон.Үүнд:

- Сумдын эрүүл мэндийн төвд 2892,8 сая төгрөг
- Өрхийн эмнэлэгт 133,8 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 259,2 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 238,7 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 11738,1 сая төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 7727,7 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 4010,4 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар: 2020 оны 4-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгуулагууд нийт 159143,5 мянган төгрөгийн авлага, 299435.0 мянган төгрөгийн өглөгтэй байна. Нийт өглөгийн 138040,1 мянган төгрөг буюу 46.1 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 11714,5 мянган төгрөг буюу 3.9 хувь нь цалингийн өглөг, 3229.8 мянган төгрөг буюу 1.1 хувь нь НДШимтгэлийн өр, 15785.9 мянган төгрөг буюу 5.3 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 48655.1 мянган төгрөг буюу 16.3 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 82009,6 мянган төгрөг буюу 27,3 хувийг бусад өр эзэлж байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

Аймгийн ИТХТ-ийн 3 тэмдэглэлийн 10 заалтад 2020 оны 01-р улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ИТХурлаар хэлэлцүүлэхэд 73.75%-тай дүгнэгдлээ.

Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо		10
Бүрэн хэрэгжсэн	100%	1
Хэрэгжих шатанд	70%	7
Хэрэгжилт хангалтгүй	30%	-
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Хугацаа болоогүй	2
Хэрэгжилтийн дундаж		73.75%

Гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахимд оруулах ажлыг “Ухаалаг Засаглал ТББ”-аар гэрээлэн гүйцэтгүүлж, аймгийн ЗДТГ-ын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахимжуулахад бэлэн болоод байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/296 тоот захирамжаар Засаг даргын нэрэмжит 8 дахь удаагийн үзлэгийг 27 суманд зохион байгууллаа. Нэрэмжит үзлэгийн дүнг нэгтгэн зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлтгэл хангаж байна.

ISO 9001:2015 олон улсын нэвтрүүлэх ажлын хүрээнд Өмнөговь, Сүхбаатар аймгийн төрийн албан хаагчид ирж туршлага судлав. “Монсертф” ХХК-ийн ерөнхий захирал Г.Билгүүн “Олон улсын чанарын менежментийн тогтолцооны стандартын” чиглэлээр сургалт хийлээ.

Санхүүгийн хяналтын чиглэлээр: Төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад сумдын Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 он, Баянчандмань

сумын политехникийн коллеж, Эрдэнэ сумын МСҮТ, Зуунмод сумын МСҮТ, Сүмбэр, Жаргалант сумын төсөвт байгууллагууд, аймгийн Музей, БСУГ, Монгол туургатан театр, ХХААЖДҮГ, Баянжаргалан сум, Баяндэлгэр, Баян, Сэргэлэн сумын төсөвт байгууллагууд, аймгийн Мал эмнэлгийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Угтаалцайдам сумын төсөвт байгууллагууд, Цээл сумын төсөвт байлгууллагууд, Батсүмбэр сумын эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж нийт 459739.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 130982.7 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт, 328757.3 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага тогтоов. Улсын байцаагчийн актаас 8894.3 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Өмнөх оны актын үлдэгдэл 109224.0 мянган төгрөгөөс 16223.8 мянган төгрөг төлөгдсөн байна. Өмнөх оны актын төлөгдөөгүй үлдэгдлийн судалгааг гаргаж Төв аймгийн прокурорын газарт шилжүүлсэн болно. Нийт актын биелэлт 10,5 хувьтай байна.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

2019 оны I ээлжийн цэрэг татлагаар Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн ангиудад алба хаасан хугацаат цэргийн алба хаагчдыг 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Зэвсэгт хүчин болон Хилийн цэргээс халагдсан алба хаагчдыг тус тус аймгийн төвд Зуунмод сумын 5 дугаар багийн байрны урд талбайд угтан авч тооцооны хуудас, бичиг баримтыг нэг бүрчлэн тулган хүлээн авч, албаа нэр төртэй хааж ирсэн дайчдад баяр хүргэн ар гэрт нь хүлээлгэн өглөө.

2020 оны I ээлжийн цэрэг татлагаар Зэвсэгт хүчний 032 дугаар анги, Хилийн цэргийн дугаар ангид цэргийн албан хаагчийг тэнцүүлж Зэвсэгт хүчний жанжин штабаас ирүүлсэн хяналтын тоог 100% биелүүлж ажиллалаа. Зэвсэгт хүчний 027 дугаар анги, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлтэй Цэргийн дайчилгааны тодотголууд хийсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/275 дугаар захирамжаар 1945 оны чөлөөлөх дайнд оролцож байсан, өдгөө Төв сайхан нутагтаа энх тунх амьдарч байгаа ахмад дайчдадаа хүндэтгэл үзүүллээ. ОХУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яамны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Джеваков Мерген Владимирович ОХУ-ын Ерөнхийлөгчийн гарын үсэгтэй "Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойн медаль"-ийг Зуунмод сумын ахмад дайчин Д.Найдан, Х.Намжилмаа, Баянжаргалан сумын ахмад дайчин Т.Далхжав, Ч.Намдаг нарт гардуулан өглөө.

Баянжаргалан суманд 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр буудлагын талбайд ил байрласан тэсрэх аюултай зэвсэг илрүүлэн бүрэн устгасан. Тухайн нутаг дэвсгэрт байлдааны зориулалтын тэсрэх бөмбөг, буудлагын сум ихээр илэрч байгаа нь ард иргэдэд аюул учруулж болзошгүй тул аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/287 дугаар захирамжаар 4.176.252 сая төгрөгийг шийдвэрлэн хүн мал эрсдэж болох газар оронд тэсрэх бөмбөгийг аюулгүй болгох ажлыг зохион явуулав.